



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

355. Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1381

356. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1382

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

357. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 55 1386

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

358. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 253 1387

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 10 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйлийн 2 дахь заалт:

“2/Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны яам;”



2/1 дүгээр зүйлийн 5-16 дахь заалт:

- “5/Батлан хамгаалах яам;
- 6/Боловсрол, шинжлэх ухааны яам;
- 7/Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам;
- 8/Соёл, спорт, аялал жуулчлалын яам;
- 9/Уул уурхай, эрчим хүчний яам;
- 10/Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам;
- 11/Хөдөлмөрийн яам;
- 12/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;
- 13/Эрүүл мэндийн яам.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “-жендэрийн хөгжлийн асуудал.” гэсний дараа “-хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого; -эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал; -төрийн өмчийн бодлого; -чөлөөт бүсийн хөгжлийн асуудал.” гэж, 5 дахь хэсгийн 9 дэх заалтын “-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.” гэсний өмнө “-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал.” гэж, мөн хэсгийн 13 дахь заалтын “-малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого;” гэсний дараа “-дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт;” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны яам;”

2/18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5-16 дахь заалт:

“5/Батлан хамгаалах яам;
6/Боловсрол, шинжлэх ухааны яам;
7/Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам;
8/Соёл, спорт, аялал жуулчлалын яам;
9/Уул уурхай, эрчим хүчний яам;
10/Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам;
11/Хөдөлмөрийн яам;
12/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;
13/Эрүүл мэндийн яам.”

3/20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт:

“4/Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайд:

-гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа;
-гадаад эдийн засгийн харилцаа;
-гадаадад байгаа Монгол Улсын иргэд, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;
-дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;
-гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээрх хамтын ажиллагаа;
-гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;
-гадаад сурталчилгаа;
-гадаад худалдааны бодлого, зохицуулалт;
-гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;
-эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, зохицуулалт;
-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.”



4/20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5 дахь заалт:

“5/Сангийн сайд:

- нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт;
- улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;
- нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- гаалийн бодлого;
- татварын бодлого;
- даатгалын бодлого;
- санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал;
- төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бодлого;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;
- зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
- концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого;
- макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.”

5/20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8 дахь заалт:

“8/Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд:

- барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;
- хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;
- орон сууцны бодлогын асуудал;
- нийтийн аж ахуйн асуудал;
- газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал;
- тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;
- төмөр замын тээврийн асуудал;
- иргэний нисэхийн асуудал;
- авто тээврийн асуудал;
- авто замын асуудал;
- далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.”



6/20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 12 дахь заалт:

“12/Уул уурхай, эрчим хүчний сайд:

- геологи, эрдэс баялгийн бодлого;
- геологийн эрэл, хайгуул, судалгааны зохицуулалт;
- газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого;
- олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;
- ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого;
- эрчим хүчний нэгдсэн бодлого;
- эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;
- сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;
- эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого;
- түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;
- хүнд үйлдвэрлэлийн бодлогын асуудал;
- агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.”

3 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “-улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого,” гэснийг “-улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн цогц бодлого, түүний хэрэгжилтийг зохицуулах, хөгжлийн төлөвлөлт хийх, салбар хоорондын бодлогын уялдааг хангах асуудал,” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 13 дахь заалтын “хүнд болон”, “-төрийн өмчийн бодлого,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 10, 16, 17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

**“ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧИЙГ
БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2012 ОНЫ 14 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “3¹.Төрийн өмчийн хороо”, “3².Хөрөнгө оруулалтын газар” гэж, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “11.Иргэний нисэхийн ерөнхий газар” гэж тус тус нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг “Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэж, “Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг “Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэж, “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг “Уул уурхай, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэж тус тус өөрчилсүгэй.

3.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг, Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “11.Иргэний нисэхийн ерөнхий газар” гэснийг, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсгийн “11.Төрийн өмчийн хороо” гэснийг, “Эдийн засгийн



хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг, Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “18.Хөрөнгө оруулалтын газар” гэснийг, “Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд” гэснийг тус тус хассугай.

4.Энэ тогтоолыг 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 8 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 253

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2014 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан ““Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсэд зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх түр журам”-д доор дурдсан өөрчлөлтийг оруулсугай:

1) Нэгдүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “2 сарын хугацаанд” гэснийг “7 сарын хугацаанд” гэж;

2) Дөрөвдүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Зорчигч ... 3,0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулахад...” гэснийг “Зорчигч ... 3,0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй барааг хоногт 1 удаагийн оролтоор гаалийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхэд...” гэж;

3) Зургаадугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг” гэснийг “2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг” гэж.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан түр журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Монгол Улсын сайд, Засгийн газрын



Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН САЙД**

Н.БАТБАЯР

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: tugin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003